“ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ” ТӨХХК
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ГАЗАР

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АНХААРУУЛГА МЭДЭЭЛЭЛ /SAFETY BULLETIN/

2026 оны 01 сарын 19 өдөр

№ 01

Цаг агаарын нөхцөл байдал эрс хүйтэрч байгаатай холбогдуулан болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж

1. Үндсэн болон нөөц цахилгаан тэжээл (дизель генератор), сэлгэн залгах төхөөрөмж, холимог тэжээлийн систем, тасралтгүй тэжээлийн систем (UPS)-ийн тоног төхөөрөмжүүдийн үзлэг, шалгалтыг тогтмол гүйцэтгэх.
2. Нөөц дизель генераторыг өдөр бүр өглөө, орой богино хугацаанд ажиллуулж шалгах. Түлшний нөөцийг хангалттай хэмжээнд байлгаж, хөдөлгүүрийн тос, хөргөлтийн шингэний түвшин, аккумуляторын цэнэгийг хянах.
3. Тоног төхөөрөмжүүд байрлах өрөөнүүдийн халаалтын хэвийн ажиллагааг шалгах, цахилгаан халаалтын тэжээлийн кабель, розетка, залгуур халж байгаа эсэхэд хяналт тавин, галын аюулгүй байдлыг ханган ажиллах.
4. Нислэгийн буулт, хөөрөлтийн үед нөөц цахилгаан үүсгүүр болох дизель генераторыг үндсэн цахилгааны тэжээлтэй зэрэгцээ ажиллагаанд байлгах.
5. Үйлдвэрлэлийн технологи үйл ажиллагаатай холбоотой эрсдэлтэй нөхцөл үүссэн тохиолдолд АБЧУГ-т sqmd@ncac.mn , 88974030 дугаарын утсаар мэдээлэх.
6. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар, зөвлөмжийг мөрдөн ажиллах.

Утас: 976-88974030
Цахим шуудан: sqmd@ncac.mn